



I–XII/2024

Тархаасан: 2025 оны 1 дүгээр сарын 16



Малын тоо 57.6 сая болж, өмнөх оноос 10.9 хувиар буурлаа


2024 оны эцэст, мал тооллогын дүнгээр, улсын хэмжээнд нийт 57.6 сая толгой мал, үүнээс 4.7 сая адуу, 5.1 сая үхэр, 480.6 мянган тэмээ, 24.5 сая хонь, 22.9 сая ямаа тоологдов. Малын тоо өмнөх оныхоос 7.0 сая (10.9%)-аар буурсан байна. Малын төрлөөр авч үзэхэд, хонь 4.9 сая (16.7%), ямаа 1.7 сая (6.9%), үхэр 276.4 мянга (5.2%), адуу 146.6 мянга (3.0%)-аар тус тус буурч, тэмээ 6.7 мянга (1.4%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, төрлөөр, мянган толгой, жил бүрийн эцэст

Малын төрөл	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
					тоо толгой	хувь
Нийт	67 343.8	71 121.5	64 681.9	57 647.9	- 7 033.9	-10.9
Адуу	4 324.4	4 821.1	4 829.7	4 683.1	- 146.6	-3.0
Үхэр	5 022.2	5 512.8	5 350.8	5 074.4	- 276.4	-5.2
Тэмээ	454.0	470.5	473.9	480.6	6.7	1.4
Хонь	31 087.0	32 747.7	29 409.4	24 490.4	- 4 918.9	-16.7
Ямаа	26 456.1	27 569.4	24 618.2	22 919.4	- 1 698.8	-6.9

2024 оны тооллогын дүнгээр, нийт сүрэгт хонь 42.5 хувь, ямаа 39.8 хувь, үхэр 8.8 хувь, адуу 8.1 хувь, тэмээ 0.8 хувийг эзэлж байна. Нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувийг мал хувийн өмчид шилжиж эхэлсэн 1990 онтой харьцуулахад ямааны эзлэх хувь 20.0 нэгж хувиар өсөж, харин хониных 15.8 нэгж хувиар, үхрийнх 2.2 нэгж хувиар, адууных 0.6 нэгж хувиар, тэмээнийх 1.3 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. НИЙТ СҮРЭГТ 5 ХОШУУ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эцэст




Манай улсын хонь, ямааны харьцаа 1990 он хүртэл 75:25 буюу 3 хонинд нэг ямаа ногдож, зохистой харьцааг хадгалж байсан. Гэвч сүүлийн жилүүдэд сүргийн бүтцэд болон малын бэлчээр ашиглалтад зохистой энэ уламжлалт харьцаа алдагдсаар 30 гаруй жил болж байна.

Тухайлбал, ямааны тоо толгойн өсөлт 1993 оноос эхэлж, ноолуур үнэд орсонтой

холбогдон 1994-2003 онд хонины тоотой ижил түвшинд болж, 2003-2009 оны ямааны тоо хонины тооноос давж, 2009-2015 онд хонины тоо толгойтой дүйцэж, 50:50 харьцаатай болсон. Бог малд хонь ямааны эзлэх хувь 2024 онд 52:48 харьцаатай болсон байна.

Улсын хэмжээнд Архангай аймаг адуу, үхрийн тоогоор, Өмнөговь аймаг тэмээний тоогоор, Өвөрхангай аймаг хонины тоогоор, Баянхонгор аймаг ямааны тоогоор тэргүүлж байна. Мал тооллогын дүнгээр Хөвсгөл аймаг нийт 5.2 сая толгой мал тоолуулж тэргүүлсэн бол, Өвөрхангай аймаг 5.1 сая толгой, Төв аймаг 4.2 сая толгой, Архангай аймаг 4.1 сая толгой, Баянхонгор аймаг 4.0 сая толгой мал тоолуулж удааллаа.

ЗУРАГ 2. МАЛЫН ТОО, сая толгой, аймаг, нийслэлээр



Малын төрлөөр авч үзвэл:

- Адуун сүргийн тоогоор Архангай аймаг 444.9 мянган толгой, Дорнод аймаг 438.2 мянган толгой, Төв аймаг 433.7 мянган толгой, Өвөрхангай аймаг 404.4 мянган толгой, Хөвсгөл аймаг 375.9 мянган толгой;
- Үхэр сүргийн тоогоор Архангай аймаг 665.0 мянган толгой, Хөвсгөл аймаг 627.6 мянган толгой, Өвөрхангай аймаг 367.4 мянган толгой, Булган аймаг 358.0 мянган толгой, Төв аймаг 356.9 мянган толгой;
- Тэмээн сүргийн тоогоор Өмнөговь аймаг 148.2 мянган толгой, Дорноговь аймаг 58.1 мянган толгой, Баянхонгор аймаг 52.6 мянган толгой, Говь-Алтай аймаг 50.1 мянган толгой, Дундговь аймаг 45.4 мянган толгой;
- Хонин сүргийн тоогоор Өвөрхангай аймаг 2485.8 мянган толгой, Хөвсгөл аймаг 2261.5 мянган толгой, Төв аймаг 2070.4 мянган толгой, Архангай аймаг 1805.9 мянган толгой, Дундговь аймаг 1611.8 мянган толгой;
- Ямаан сүргийн тоогоор Баянхонгор аймаг 2391.0 мянган толгой, Говь-Алтай аймаг 1919.1 мянган толгой, Хөвсгөл аймаг 1894.6 мянган толгой, Өвөрхангай аймаг 1858.4 мянган толгой, Ховд аймаг 1817.5 мянган толгойгоор тэргүүлж байна.

Нийт малын тоогоор Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 507.9 мянган толгой, Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 487.1 мянган толгой, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум 395.3 мянган толгой, Өвөрхангай аймгийн Баянгол сум 381.9 мянган толгой, Хөвсгөл аймгийн Арбулаг сум 381.7 мянган толгой мал тоолуулж тэргүүлжээ.


Улсын хэмжээнд 2024 онд оны эхний төллөх насны 30.0 сая хээлтэгч малын 19.1 сая (63.6%) нь төллөжээ. Гүүний 61.3 хувь, үнээний 68.4 хувь, ингэний 42.7 хувь, эм хонины 65.7 хувь, эм ямааны 60.7 хувь нь төллөсөн байна.

ХҮСНЭГТ 2. 1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, мянган толгой, жил бүрийн эцэст

Эх малын төрөл	Оны эхний хээлтэгч		Төллөсөн хээлтэгч		Төллөлтийн хувь	
	2023	2024	2023	2024	2023	2024
Бүгд	30 855.7	29 993.4	22 679.8	19 063.1	73.5	63.6
Гүү	1 607.1	1 704.3	1 093.7	1 044.7	68.1	61.3
Үнээ	2 203.9	2 193.6	1 653.4	1 501.2	75.0	68.4
Ингэ	173.5	177.0	79.5	75.6	45.8	42.7
Эм хонь	14 974.7	14 288.9	11 613.1	9 383.7	77.6	65.7
Эм ямаа	11 896.5	11 629.7	8 240.1	7 057.9	69.3	60.7

Төллөлтийн хувь өмнөх оноос 9.9 нэгж хувиар, гүүнийх 6.8 нэгж хувиар, үнээнийх 6.6 нэгж хувиар, ингэнийх 3.1 нэгж хувиар, эм хониных 11.9 нэгж хувиар, эм ямааных 8.6 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 3. ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, сая толгой, жил бүрийн эцэст



Бойжуулсан төл 2024 онд 16.2 сая болж, өмнөх оноос 2.1 сая толгой 11.4% буурчээ. Бойжилтын хувь 85.1% болж, өмнөх оноос 4.4 нэгж хувиар өссөн байна. Төрлөөр авч үзвэл, гарсан унаганы 89.9 хувь, тугалын 92.0 хувь, ботгоны 95.2 хувь, хурганы 84.4 хувь, ишигний 83.7 хувь нь бойжсон байна.

ХҮСНЭГТ 3. БОЙЖУУЛСАН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эцэст, мянган толгой

Төлийн төрөл	Гарсан төл		Бойжуулсан төл		Төл бойжилтын хувь	
	2023	2024	2023	2024	2023	2024
Бүгд	22 719.5	19 079.7	18 323.0	16 231.9	80.6	85.1
Унага	1 093.7	1 044.7	950.0	938.8	86.9	89.9
Тугал	1 653.4	1 501.2	1 474.5	1 381.5	89.2	92.0
Ботго	79.5	75.6	75.3	72.0	94.8	95.2
Хурга	11 635.7	9 394.0	9 455.4	7 925.3	81.3	84.4
Ишиг	8 257.3	7 064.2	6 367.8	5 914.3	77.1	83.7

Оны эхний малын 14.5 хувь буюу 9.4 сая том мал 2024 онд зүй бусаар хорогдлоо. Нийт хорогдсон малын 33.1 мянга (0.4%) нь өвчнөөр хорогдсон байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 5.0 сая, ямаа 3.0 сая, үхэр 800.1 мянга, адуу 558.9 мянга, тэмээ 11.2 мянгаар хорогдсон байна. Нийт хорогдсон малын 31.6 хувийг ямаа, 53.8 хувийг хонь эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эцэст

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2021	2022	2023	2024	2021	2022	2023	2024
	мянган толгой				хувь			
Дүн	3 012.3	667.5	4 921.5	9 364.1	4.49	0.99	6.92	14.48
Адуу	118.4	34.2	269.7	558.9	2.89	0.79	5.59	11.57
Үхэр	188.4	56.8	415.5	800.1	3.98	1.13	7.54	14.95
Тэмээ	22.2	2.0	8.8	11.2	4.70	0.43	1.88	2.37
Хонь	1 123.5	301.8	2 174.2	5 037.6	3.74	0.97	6.64	17.13
Ямаа	1 559.9	272.7	2 053.3	2 956.3	5.63	1.03	7.45	12.01


Том малын хорогдол 2024 онд Сүхбаатар аймагт 1.8 сая (19.5%), Хэнтий аймагт 1.5 сая (16.1%), Архангай аймагт 993.3 мянга (10.6%), Төв аймагт 843.1 мянга (9.0%), Дорноговь аймагт 682.7 (7.3%) мянган мал хорогдсон нь том малын хорогдлын 62.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 4. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр, мянган толгой



2024 онд нийт 1577.4 мянган тонн хадлан бэлтгэсэн нь өмнөх оныхоос 12.7 мянган тонн буюу 0.8 хувиар өссөн байна. Бэлтгэсэн хадланг аймгаар авч үзэхэд, Баянхонгор, Архангай, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт 725.3 тонноос 39.8 мянган тонноор буюу 1.1 - 39.1 хувиар буурч, харин бусад аймаг болон Улаанбаатар хотод 1.5 мянган тонноос 52.4 мянган тонн буюу 4.7 хувиас 66.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 5. БЭЛТГЭСЭН ХАДЛАН, аймаг, нийслэлээр, мянган тонн



Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2024 онд 84 толгой болж, өмнөх оноос 7 толгойгоор буурсан байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Булган, Архангай, Хөвсгөл, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв, Хэнтий, Говьсүмбэр, Баян-Өлгий аймгуудад улсын дунджаас 1 - 1140 толгойгоор их байна. Бусад аймгуудад улсын дунджаас 3 - 63 толгойгоор бага байна.

Улсын хэмжээнд мал тооллогын дүнгээр 249.5 мянган малтай өрх тооллогод хамрагдаж, өмнөх оноос 1.6 мянган өрхөөр буюу 0.6 хувиар өссөн байна. Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэж үзэхэд, 50 хүртэлх малтай өрх 13.0 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 4.4 хувиар өсөж, 201-500 малтай өрх 4.7 хувиар, 501-999 малтай өрх 12.9 хувиар, 1000-2000 малтай өрх 28.3 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 49.0 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 5. МАЛТАЙ ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, малын тооны бүлгээр, жил бүрийн эцэст

	Малтай өрхийн тоо				Малтай нэг өрхөд ногдох малын толгой			
	2021	2022	2023	2024	2021	2022	2023	2024
Бүгд	246 303	248 296	247 873	249 450	272	285	260	230
50 хүртэлх малтай	53 577	52 748	56 706	64 084	24	24	24	23
51-200	85 086	83 751	85 947	89 734	118	119	118	116
201-500	67 035	67 316	66 407	63 275	320	322	321	319
501-999	29 857	32 332	29 959	26 094	683	687	680	674
1000-2000	10 195	11 519	8 460	6 062	1 218	1 226	1 208	1 189
2001-ээс дээш малтай	553	630	394	201	2 507	2 483	2 492	2 472

Малтай нэг өрхөд ногдох малын тоо 2024 онд дунджаар 230 болж, өмнөх оноос 30 толгой мал буюу 11.5 хувиар буурсан байна. Малтай нэг өрхөд 19 адуу, 20 үхэр, 2 тэмээ, 98 хонь, 91 ямаа ногдож байна. Малтай нэг өрхөд ногдох үхэр 1, хонь 21, ямаа 8 толгойгоор өмнөх оноос тус тус буурч, харин адуу, тэмээний тоо өөрчлөлтгүй байна.

Мал тооллогын 2024 оны дүнгээр нийт малтай өрхийн 78.5 хувь буюу 195.7 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 6.5 мянга буюу 3.4 хувиар өсжээ. Малчин өрхийг малын тоогоор нь бүлэглэж үзэхэд 50 хүртэлх малтай өрх 25.1 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 10.6 хувиар өссөн бол, 201-500 малтай өрх 2.4 хувиар, 501-999 малтай өрх 12.1 хувиар, 1000-2000 малтай өрх 28.1 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 48.0 хувиар тус тус буурсан байна.

Малчин нэг өрхөд ногдох малын тоо 2024 онд дунджаар 269 болж, өмнөх оноос 40 толгой мал буюу 12.9 хувиар буурсан байна. Малчин нэг өрхөд 21 адуу, 23 үхэр, 2 тэмээ, 115 хонь, 108 ямаа ногдож байна. Малчин нэг өрхөд ногдох адуу 1, үхэр 1, ямаа 10, хонь 28 толгойгоор өмнөх оныхоос тус тус буурч, харин тэмээний тоо өөрчлөлтгүй байна.


ХҮСНЭГТ 6. МАЛЧИН ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, малын тооны бүлгээр, жил бүрийн эцэст

	Малчин өрхийн тоо				Малчин нэг өрхөд ногдох малын толгой			
	2021	2022	2023	2024	2021	2022	2023	2024
Бүгд	188 605	190 776	189 284	195 746	323	339	309	269
50 хүртэлх малтай	26 916	26 411	28 605	35 771	27	26	26	26
51-200	62 588	61 224	63 814	70 556	122	122	121	119
201-500	59 637	59 902	59 137	57 733	323	326	324	321
501-999	28 894	31 256	28 993	25 486	684	688	681	675
1000-2000	10 034	11 365	8 352	6 001	1 217	1 225	1 207	1 188
2001-ээс дээш малтай	536	618	383	199	2 494	2 477	2 488	2 473

Мал тооллогын 2024 оны дүнгээр малчин өрхийн 83.2 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 75.5 хувь нь телевизортой, 63.6 хувь нь автомашинтай, 48.8 хувь нь мотоциклтой байна.


Цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 2024 онд 162.9 мянга болж, өмнөх оноос 6.3 мянга (4.0%), телевизортой өрхийн тоо 147.8 мянга болж, өмнөх оноос 6.1 мянга (4.3%), автомашинтай өрхийн тоо 124.4 мянга болж, өмнөх оноос 10.8 мянга (9.5%), мотоциклтой өрхийн тоо 95.4 мянга болж, өмнөх оноос 2.1 мянга (2.3%) -аар тус тус өссөн байна.

ЗУРАГ 6. МАЛЧИН ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, аймаг, нийслэлээр, 2024 он




Мал тооллогын 2024 оны дүнгээр, манай улсын хөдөлмөр эрхэлдэг дөрвөн хүн тутмын нэг нь буюу 308.7 мянган малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байна. Малчдын тоо өмнөх оноос 10.4 мянга буюу 3.5 хувиар өссөн байна. Нийт малчдын 185.4 мянга буюу 60.1 хувь нь эрэгтэй, 123.3 мянга буюу 39.9 хувь нь эмэгтэй малчид байна. Малчдын тоог аймгаар, өмнөх оныхтой харьцуулан авч үзэхэд, Говьсүмбэр Баянхонгор, Дорноговь, Өмнөговь аймагт 5 - 338 -аар буурсан бол бусад аймгуудад 27 - 1233 -аар өссөн байна.

ЗУРАГ 7 МАЛЧДЫН ТОО, аймаг, нийслэлээр



Нийт малчдыг насны бүлгээр авч үзэхэд 5.6 хувь нь 24 хүртэлх насны, 18.9 хувь нь 25-34 насны, 27.1 хувь нь 35-44 насны, 27.2 хувь нь 45-54 насны, 14.5 хувь нь 55-64 насны, 6.7 хувь нь 65 ба түүнээс дээш насны малчид байна.

ЗУРАГ 8. МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ, насны бүлгээр, 2024 онд



Нийт малчдын 62.1 хувь нь буюу 191.6 мянган малчин эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Даатгалд хамрагдсан малчдын 146.1 мянган малчин буюу 76.2 хувь нь 25-54 насныхан байна.

Нийт малчдын 53.5 хувь нь буюу 165.1 мянган малчин зээлтэй байна. Зээл авсан малчдын 25-34 насны малчид 17.7 хувь, 35-44 насны малчид 30.4 хувь, 45-54 насны малчид 30.1 хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төл бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.



Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100 -гаар үржүүлж тооцно.

Эх үүсвэр:

ҮСХ, Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого 2024

Мэдээлэл авах холбоос:

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархах хуваарь:

2025 оны 2 дугаар сарын 16

Эдийн засгийн статистикийн газрын
дарга М.Оюунжаргал
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Б.Алтансүвд
ахлах мэргэжилтэн Э.Анар
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



7014-1212